

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Дулаан шарын гол” ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2024/01/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: <a href="#">www.audit.mn</a>	Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас:70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас:70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитор: З.Мөнгөнцэцэг Утас: 7037308 Цахим хаяг: munguntsetsegz@audit.gov.mn
Дархан-Уул аймаг 2023 он	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



### ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-14 дугаар баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3088, Факс: (976) 7037-3088  
Цахим хуудас: darkhanul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.15 № 045  
Талай \_\_\_\_\_ нөмөр \_\_\_\_\_

"ДУЛААН ШАРЫН ГОЛ" ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ П.БАЯРЦЭЦЭГ  
ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Дулаан шарын гол" ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

"Дулаан шарын гол" ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Компани нь 2023 оны техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлээр 139,035.2 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, өмнөх онтой харьцуулахад алдагдлыг 100 хувь бууруулсан байна.

#### Аудитын гол асуудал

Тайлант онд Эрчим хүчний зохицуулах хорооны 2023 оны 133 дугаар тогтоолоор компанийн хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг 28 хувиар, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2023 оны 20 дугаар тогтоолоор цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг 20 хувиар тус тус нэмэгдүүлжээ.

#### Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Компанийн 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангах хүрээнд 30 багц ажил төлөвлөж, гүйцэтгэлийг 100 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

★ 0000000000

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,678,572.87	20,815,762.99
1.1.02	Дансны авлага	217,452,814.85	211,985,090.91
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	0.00	2,202,050.00
1.1.04	Бусад авлага	6,316,904.50	5,916,829.37
1.1.06	Бараа материал	58,860,055.29	105,585,537.20
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	54,564,130.23	60,972,621.44
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	340,872,477.74	407,477,891.91
1.2.01	Үндсэн хөрөнгө	6,252,639,296.89	6,029,294,992.40
1.2.02	Биет бус хөрөнгө	106,965,408.50	89,356,000.00
1.2.03	Биологийн хөрөнгө	3,230,000.00	3,230,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,362,834,705.39	6,121,880,992.40
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,703,707,183.13</b>	<b>6,529,358,884.31</b>
2.1.1.01	Дансны өглөг	246,071,542.94	206,848,636.28
2.1.1.03	Татварын өр	655,629,542.06	721,699,294.30
2.1.1.04	НДШ - ийн өглөг	431,203,369.46	61,292,348.78
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	2,064,076.00	1,915,968.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,334,968,530.46	991,756,247.36
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	9,389,927.62	349,569.12
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	9,389,927.62	349,569.12
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,344,358,458.08	992,105,816.48
2.3.01	Өмч: - төрийн	6,525,993,994.35	6,525,993,994.35
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	946,898,835.21	963,314,968.71
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	600,705,327.18	610,705,327.18
2.3.09	Хуримтлагдсан ашиг	(2,714,249,431.69)	(2,562,761,222.41)
2.3.11	Эздийн өмчийн дүн	5,359,348,725.05	5,537,253,067.83
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>6,703,707,183.13</b>	<b>6,529,358,884.31</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>3,359,315,849.87</b>	<b>4,196,208,844.52</b>
2	<b>Борлуулалтын өртөг</b>	<b>3,403,412,127.79</b>	<b>3,946,008,901.98</b>
3	Нийт ашиг (алдагдал)	(44,096,277.92)	250,199,942.54
4	Бусад орлого	231,078,796.67	126,198,827.84
6	Ерөнхий ба удирдлагын зардал	128,050,343.91	163,963,566.04
7	Бусад зардал	105,983,819.64	62,713,831.39
9	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		1,420,503.59
10	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		3,545,454.55
11	Олз, гарзын дүн		4,965,958.14
12	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(47,051,644.80)</b>	<b>154,687,331.09</b>
13	Орлогын татварын зардал		15,652,102.31
14	Татварын дараах ашиг (алдагдал)	(47,051,644.80)	139,035,228.78
15	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>(47,051,644.80)</b>	<b>139,035,228.78</b>
16	Орлогын нийт дүн	-	-
17	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>1</b>	<b>2022 оны 01-р сарын 01-ээрх үлдэгдэл</b>	<b>6,525,993,994.35</b>	<b>916,710,028.32</b>	<b>508,162,728.28</b>	<b>(2,669,957,286.89)</b>	<b>5,280,909,464.06</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-
4	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
5	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	-	-	-	(47,051,644.80)	(47,051,644.80)
6	Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	92,542,598.90	-	92,542,598.90
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	30,188,806.89	-	2,759,500.00	32,948,306.89
<b>9</b>	<b>2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>6,525,993,994.35</b>	<b>946,898,835.21</b>	<b>600,705,327.18</b>	<b>(2,714,249,431.69)</b>	<b>5,359,348,725.05</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	6,525,993,994.35	946,898,835.21	600,705,327.18	(2,714,249,431.69)	5,359,348,725.05
12	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
13	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	-	-	-	139,035,228.78	139,035,228.78
14	Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	10,000,000.00	-	10,000,000.00
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	16,416,133.50	-	12,452,980.50	28,869,114.00
<b>17</b>	<b>2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>6,525,993,994.35</b>	<b>963,314,968.71</b>	<b>610,705,327.18</b>	<b>(2,562,761,222.41)</b>	<b>5,537,253,067.83</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>2,551,987,503.21</b>	<b>3,110,048,140.01</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,830,738,077.80	2,061,941,639.33
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	600,000,000.00	970,000,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	121,249,425.41	78,106,500.68
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>2,527,771,149.55</b>	<b>3,007,766,487.15</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	989,791,265.47	1,235,406,019.15
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	287,000,000.00	763,050,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	490,818,391.99	446,843,708.23
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	270,566,082.04	13,259,222.03
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн	82,396,484.00	81,429,169.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	210,473,751.24	301,862,267.51
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	673,155.00	824,670.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	196,052,019.81	165,091,431.23
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	24,216,353.66	102,281,652.86
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	-	-
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>23,815,181.82</b>	<b>85,144,462.74</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	23,815,181.82	85,144,462.74
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(23,815,181.82)</b>	<b>(85,144,462.74)</b>
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	401,171.84	17,137,190.12
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>3,277,401.03</b>	<b>3,678,572.87</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>3,678,572.87</b>	<b>20,815,762.99</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд		Хэмжих нэгж	2023 он		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Боловсруулсан	ДЭХ	Гкал	39,200.0	40,896.0	1,696.0	104.3
	Дотоод хэрэгцээний дулаан эрчим хүч	хувиар	хувь	8.2	8.2	0.0	100.5
		биетээр	гкал	3,200.0	3,200.0	-	100.0
	Эрчим хүч түгээлт	ДЭХ	гкал	36,000.0	37,696.0	1,696.0	104.7
	Олборлох ус		м3	308,918.9	254,728.0	(54,190.9)	82.5
	Борлуулах ус		м3	229,613.9	240,293.0	10,679.1	104.7
	Татан зайлуулах бохир ус		м3	271,053.0	222,092.0	(48,961.0)	81.9
2	<b>Нийт орлого</b>		<b>мян.төг</b>	<b>4,339,412.1</b>	<b>4,327,373.6</b>	<b>(12,038.5)</b>	<b>99.7</b>
	Үүнээс:	Үндсэн үйл ажиллагааны орлого	мян.төг	3,365,312.2	3,314,390.6	(50,921.6)	98.5
		Үндсэн бус үйл ажиллагааны орлого	мян.төг	92,281.7	131,164.8	38,883.1	142.1
		Төсвийн санхүүжилт	мян.төг	881,818.2	881,818.2	-	100.0
3	<b>Нийт зардал</b>		<b>мян.төг</b>	<b>4,339,412.1</b>	<b>4,188,338.4</b>	<b>(151,073.7)</b>	<b>96.5</b>
	Үүнээс:	Үйл ажиллагааны зардал	мян.төг	3,889,512.1	3,742,527.9	(146,984.2)	96.2
		Үйл ажиллагааны бус зардал	мян.төг	-	-	-	-
	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал		мян.төг	449,900.0	445,810.5	(4,089.5)	99.1
4	Татварын өмнөх ашиг(алдагдал)		мян.төг	-	139,035.2	139,035.2	-
5	<b>Цэвэр ашиг (алдагдал)</b>		<b>мян.төг</b>	<b>-</b>	<b>139,035.2</b>	<b>139,035.2</b>	<b>-</b>
6	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ноогдох зардал		төгрөг	1.29	1.26	(0.0)	98.0
7	Нийт авлага		мян.төг	119,650.0	220,104.0	100,454.0	184.0
8	Нийт өглөг		мян.төг	1,052,000.0	992,105.8	(59,894.2)	94.3
9	Нийт ажиллагсдын тоо		хүн	101	86	(15.0)	85.1
10	Нийт цалингийн сан		мян.төг	1,535,328.2	1,423,673.4	(111,654.8)	92.7
11	Жишмэл түлшний хувийн зарцуулалт		кг/гкал	196.9	191.2	(5.7)	97.1
12	<b>Их засвар, хөрөнгө оруулалт, ТЗБАХ</b>		<b>мян.төг</b>	<b>219,671.7</b>	<b>206,165.5</b>	<b>(13,506.2)</b>	<b>93.9</b>

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 22,349.9 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup>-д 442,8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 4,416.1 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 1 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй 17,491.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

#### 3.1 Төлбөрийн акт

- Аудитаар сарын үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлс олгох журмыг баримтлаагүйгээс 442,819.00 төгрөгийн цалин илүү олгосон нь компанийн гүйцэтгэх захирлын 2022 оны А/27 дугаар тушаалаар баталсан "Компанийн ажилтнуудын сарын үйл ажиллагааны нэмэгдэл хөлс болон жилийн үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлс олгох журам"-ын 3.4-т "3 ба түүнээс дээш хоногийн чөлөө авсан, өвчилсөн, дагалдан болон үндсэн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны ажилтнууд түр хугацаагаар ажиллах хугацаанд сарын үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлс олгохгүй" гэж заасантай нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

#### 3.2 Албан шаардлага

- Аудитаар Хөдөлмөрийн тухай хуульд нийцээгүй, сарын үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлс олгох журмын дагуу сахилгын шийтгэлийн хугацаа дуусаагүй 5 ажилтанд 4,416,129.00 төгрөгийн нэмэгдэл хөлс олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8-т "Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно", 123.9-т "Ажил олгогч энэ хуулийн 123.8-д заасан хугацаанаас өмнө ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцож болох бөгөөд энэ тухай ажилтанд бичгээр мэдэгдэнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул "Компанийн ажилтнуудын сарын үйл ажиллагааны нэмэгдэл хөлс болон жилийн үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлс олгох журам"-д өөрчлөлт оруулах албан шаардлага хүргүүлээ.

#### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримттай холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

- Аж ахуйн нэгж, байгууллагаас 17,491.0 мянган төгрөгийн худалдан авалтын цахим төлбөрийн баримтыг гаргуулан аваагүй, нягтлан бодох бүртгэлд хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар ажил гүйлгээг бүртгэсэн нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 01

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

дүгээр хавсралтын 6.5 дахь хэсэгт “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QRкодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

- Холбогдох хууль тогтоомжийн дагуу анхан шатны баримтын бүрдэл ханган, цахим төлбөрийн баримтаар баталгаажуулан ажиллах

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>2</sup>-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>2</sup> Шалгаагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Сарын үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлс олгох журмыг баримтлаагүйгээс 3 ажилтанд 442.8 мянган төгрөгийн цалин илүү олгосон байна.	1	442.8	1	442.8	-	-	-	-	-	-	-	-	-
Хөдөлмөрийн тухай хуульд нийцээгүй, сарын үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлс олгохдоо сахилгын шийтгэлийн хугацаа дуусаагүй 5 ажилтанд 4,416.1 мянган төгрөгийн сарын үр дүнгийн урамшуулал олгосон байна.	1	4,416.1	-	-	1	4,416.1	-	-	-	-	-	-	-
Аж ахуйн нэгж, байгууллагаас 17,491.0 мянган төгрөгийн цахим төлбөрийн баримтыг гаргуулан аваагүй, нягтлан бодох бүртгэлд хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар ажил гүйлгээг бүртгэсэн байна.	1	17,491.0	-	-	-	-	1	17,491.0	-	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>22,349.9</b>	<b>1</b>	<b>442.8</b>	<b>1</b>	<b>4,416.1</b>	<b>1</b>	<b>17,491.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

